

МОНГОЛ УЛС, АНУ-ЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ШИНЭ ӨРНӨЛТ

*М.ХУРМЕТХАН**

ОРШИЛ

АНУ-ын эсрэг 2001 оны есдүгээр сарын 11-ний өдөр алан хядах үйл ажиллагаа явагдсан нь АНУ-д төдийгүй дэлхий нийтийг цочирдуулсан гүн эмгэнэлт явдал болсон билээ. Энэхүү жигшүүрт хэрэг явдлын улмаас олон мянган хүн амь насаа алдаж, их хэмжээний хохирол учирсанд Монголын төр засаг, монголын ард түмэн америкийн ард түмэн, түүний засгийн газартай зүрх сэтгэлээрээ хамт байгаагаа илэрхийлсэн билээ. Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабанди "Монгол улсын төр, засаг, ард түмнийхээ нэрийн өмнөөс Ерөнхийлөгч Ж.Буш, түүний засгийн газар, аллага хядлагад өртсөн гэм зэмгүй олон мянган иргэдийн ар гэр, төрөл төрөгсөд болон Америкийн ард түмэнд гүн эмгэнэл илэрхийлье. Алан хядагчдын хандлагад өртөж бэртэж гэмтсэн, шархдсан хүмүүст Монгол Улс бололцооны хирээр туслахад бэлэн байна"¹ хэмээн мэдэгдсэн билээ. Дэлхий ертөнцийг илүү аюулгүй тайван орчинд амьдрах, олон нийтийн хүсэл тэмүүлэл, алан хядах аливаа илэрлийг даамжируулахгүй тэмцэх талаар явуулж буй АНУ, дэлхийн хамтын нийгэмлэгийн бүхий л хүчин чармайлтыг Монгол Улс бүрэн дэмжиж байгаа билээ.

Өнөөгийн олон улсын амьдралд үүссэн нөхцөл байдалд Монгол Улс, АНУ-тай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн, олон тулгуурт гадаад бодлогынхоо хүрээнд АНУ-тай стратегийн түншлэлийн харилцаа тогтоох нь Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнол, ирээдүйн хөгжил, дэвшилд их хувь нэмэртэй юм. Чухамдаа Монгол Улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтсон 1987 оны нэгдүгээр сарын 27-ноос хойшхи улиран өнгөрсөн 15 жилийн хугацаанд хоёр орны хооронд өрнөсөн улс төр, худалдаа, эдийн засаг, буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалт, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны бодит байдал үүнийг батлан харуулж байгаа юм.

* М.Хурметхан - доктор, профессор

Нэг. Харилцааны түүхээс

1921 оны 9 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар АНУ-ын Засгийн газарт хандаж дипломат харилцаа тогтоох асуудлыг санаачилж байжээ. АНУ 1945 он хүртэл Чанкайши-гийн Засгийн газрын байр суурийг дэмжих бодлогынхоо хүрээнд манай улсын тусгаар тогтнолыг үгүйсгэж ирсэн. Харин 1945 оны Ялтын дээд хэмжээний уулзалтын үеэр АНУ БНМАУ-ын статус-квог хүлээн зөвшөөрсөн билээ.

1961 онд манай улс НҮБ-д элссэнээс хойш, ялангуяа 1970-аад онд америкийн тал дипломат харилцаа тогтоох асуудлыг санаачилж, яриа хэлэлцээ явагдсан боловч тухайн үеийн улс төрийн тодорхой шалтгааны улмаас асуудал хойшлогдсон юм.

Монгол Улс, АНУ-ын хооронд 1987 оны 1 дүгээр сарын 27-нд дипломат харилцаа тогтоосон. Ийнхүү харилцаа тогтоох санаачилгыг энэ удаа ч мөн АНУ-ын тал гаргасан байна.

АНУ-аас Монголд суух анхны элчин сайд Р.Уильямс 1988 онд ирж итгэмжлэх жуух бичгээ барьсан бөгөөд тэрбээр Вашингтонд байнга сууж, хааяа Улаанбаатарт ирж ажиллаж байв. АНУ-аас Монголд суух тав дахь элчин сайд Ж.Дингэр 2000 оны 11 дүгээр сард ИЖБ-ээ барьсан. Монгол Улсаас АНУ-д суух анхны элчин сайд Г.Нямдоо 1989 онд, элчин сайд Ж.Чойнхор 1995 онд тус тус итгэмжлэх жуух бичгээ барьсан.

Америкийн тал байнгын ЭСЯ-аа 1988 оны 4 дүгээр сард Улаанбаатарт, манайх байнгын ЭСЯ-аа Вашингтонд 1989 оны 3 дугаар сард тус тус нээсэн байна.

Хоёр. Монгол Улс, АНУ-ын улс төрийн харилцаа

Дэлхий дахинд гарсан өөрчлөлт, Монгол оронд өрнөсөн ардчилал, шинэчлэлийн үйл явц нь АНУ-ын зүгээс манай улсын талаар баримтлах бодлого, хандлага, үйл ажиллагаанд амин чухал нөлөө үзүүлсэн хүчин зүйл болсон билээ. Тухайлбал, 1990 оны тавдугаар сард АНУ-ын Конгрессийн төлөөлөгчдийн танхимын Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн салбар хороо, Монгол Улстай харилцах асуудлыг анх удаа хэлэлцэн, Монгол Улстай харилцах асуудлыг анх удаа хэлэлцэн, Монголд өрнөсөн шинэчлэлийг нааштай үнэлээд хоёр талын харилцааг идэвхжүүлэх, Монголд боломжтой тусламж дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж үзсэн билээ.

Монгол Улсад ардчилал, шинэчлэлийн үйл явц идэвхжин гүнзгийрэхийн хирээр, Монгол Улсыг дэмжсэн АНУ-ын байр суурь улам батжин, хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа үр дүнтэй түргэн

хөгжиж, улс төрийн яриа хэлэлцээний түвшин өндөр шатанд хүрчээ.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдууд, УИХ-ын дарга нар, УИХ-ын гишүүд болон удаа дараагийн Засгийн газрын гишүүд зэрэг өндөр албаны хүмүүс АНУ-д албан ёсны болон ажлын айлчлал хийлээ. Тэрчилэн АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бейкер /хоёр удаа/, М.Олбрайт Монголд айлчилав. 1995 онд хоёр улсын төрийн тэргүүнүүд Нью-Йорк хотноо уулзав. 1995 онд АНУ-ын Тэргүүн хатагтай Монголд айлчилсан бол мөн өнгөрсөн хугацаанд АНУ-ын Сенатын гишүүд, Засаг захиргааны хийгээд цэргийн удирдах албаны хүмүүс удаа дараа Монголд айлчилав.

Эдгээр айлчлал хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны түвшинг эрс дээшлүүлсэн, түргэн хөгжих суурийг тавьсан чухал ач холбогдолтой хүчин зүйл болсон билээ.

Ялангуяа. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга М.Олбрайтын айлчлалын үеэр 1998 оны 5 дугаар сард хоёр тал Монгол Улс, АНУ-ын харилцааны тухай мэдэгдэл гарсныг онцлон дурдах хэрэгтэй билээ. Энэхүү хамтарсан мэдэгдэл нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг улс төрийн аргаар сахин хангахад АНУ-ын зүгээс дэмжих тухайгаа олон улсын хэмжээнд мэдэгдэж анхны улс төрийн баримт бичиг болсон билээ. Мөн түүнчлэн улс төрийн харилцааны өөр нэгэн чухал асуудал бол Монгол Улсын тухайд АНУ-ын дэмжлэгийг дэлхий дахинд нотолсон баримт бичгүүд болно. Үүнд АНУ-ын конгресс, /1991.3-р сар/, Сенат /1991 оны 7-р сар/, тогтоол, хамтарсан тогтоол /1991.10-р сар/ болон 1998 оны 3-р сарын 3-нд АНУ-ын Сенат, танхимын хамтарсан тогтоолд Монголд хоёр болон олон талын хүрээнд тусламж, дэмжлэгийг цаашид ч үзүүлэх Америкийн хөрөнгө оруулагчдаас Монголд хөрөнгө оруулж хамтран ажиллахыг тус тус уриалсан.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улс, АНУ-ын хооронд хэд хэдэн чухал гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурсан нь Монгол, Америкийн харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлж бэхжүүлэхэд чухал алхам болсон байна. Монгол, Америкийн хооронд соёл, боловсрол, шинжлэх ухаан, техник, консул, худалдаа зэрэг салбарыг хамарсан 20-иод суурь, гэрээ, хэлэлцээр байгуулагдан хүчин төгөлдөр үйлчилж байна.

1949 оны 10 дугаар сард АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын орлогч Т.Пикеринг Монгол Улсад ажлын айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандитай уулзаж, АНУ-ын дэд ерөнхийлөгч А.Гороос илгээсэн захидлыг гардуулсан юм.

Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун 2000 оны 9 дүгээр албаны хүмүүстэй уулзсан ажээ. Энэхүү ажлын айлчлалын явцад Монгол Улсын шинэ Засгийн газрын дотоод, гадаад бодлогын зорилт, мөрийн хөтөлбөрийг танилцуулах, АНУ-ын талаас манай Засгийн газартай хамтран ажиллаж, шаардлагатай туслалцааг авах талаар ярилцан тохиролцов.

2001 оны 11 дүгээр сард Ерөнхий сайд Н.Энхбаяр АНУ-д албан ёсны айлчлал хийж, Ерөнхийлөгч Ж.Буш, Конгрессын удирдлага, гишүүдтэй уулзаж, хоёр талын харилцааг стратегийн түншлэлийн хүрээнд хөгжүүлэхээр ярилцсан нь улс төрийн чухал ач холбогдолтой болов. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр “Бидний сонголт бол манай ард түмний хүсэл. Тиймээс эргэлт буцалтгүй юм. Монгол Улс АНУ-ыг урт удаан хугацааны стратегийн түшиц гэж үздэг.

Энэхүү ухамсартай сонголт нь Монгол Улсын амин чухал эрх ашигт нийцэж байгаа юм² гэжээ.

АНУ-ын удирдагч нар Азид ардчиллын билэг тэмдэг болж байгаа Монгол Улстай харилцах өндөр ач холбогдол өгдөг билээ. АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяртай уулзахдаа, “Бейкер гуайн очсон оронд очилгүй яахав” гэж мэдэгдэж Монгол Улсад Ерөнхийлөгч өөрийн биеэр айллах нь нэгэн сайхан сэтгэгдэл төрүүлж байна. АНУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ж.Дингер “Манай хоёр орны Засгийн газар, ард түмний харилцаа улам нягтарч, ойр дотно болж байна. Цаашид улам бүр хөгжих нь дамжиггүй”³ хэмээн 2001 оны 10-р сарын 4-нд өгсөн ярилцлагандаа тэмдэглэжээ.

Дээрхи бүхий үйл явдал манай хоёр улсын харилцаа жилээс жилд өргөжин хөгжиж, улам гүнзгийрэн стратегийн түншлэлийн хэмжээнд хүрч очсоныг харуулж байна. Энэхүү харилцааны ардчиллын зарчим, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх зарчим, НҮБ-ын дүрэмд заасан тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүндэтгэх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох, харилцан ойлголцох, хамтран ажиллах зарчимд тулгуурлаж байгаа билээ.

АНУ, Ази Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, аюулгүй байдлын хамтын ажиллагааны олон талт үйл явцад Монгол Улс идэвхтэй орж ажиллахад дэмжлэг үзүүлж, тус бүс нутагт гадаад бодлогын асуудлаар тогмтол яриа хэлэлцээ явуулах эхлэл тавигдан амжилттай хэрэгжиж байгааг ч дурьдах хэрэгтэй.

Гурав. Худалдаа, эдийн засгийн харилцаа

Монгол Улс, АНУ-ын хооронд худалдааны тусгай хэлэлцээр 1991 онд байгуулагдан, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн үндсийг тавьсан билээ. 1999 оны 6 дугаар сард АНУ-ын Конгрессоос манай оронд худалдааны хэвийн нөхцөлийг байнгын олгох шийдвэр гаргасан ба 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн АНУ-ын Худалдааны хөнгөлөлтийн системд (CSP) Монгол Улсыг хамруулах шийдвэр гаргасан нь хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөн далайцтай хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж өглөө. Хоёр орны худалдаа, жилээс жилд өсөн нэмэгдэж 2000 онд 110,1 сая ам.долларт хүрсэнээс манай экспорт 85,8 сая ам.доллар болсон нь урьд оныхоос нийт худалдааны хэмжээ 30 орчим хувиар нэмэгджээ. Монголоос АНУ-д сүлжмл бүтээгдэхүүн, цагаан тугалга болон бусад ашигт малтмал, тэмээний ноос, ямааны ноолуур зэргийг экспортлож, АНУ-аас машин, тоног төхөөрөмж, хүнсний болон химийн бүтээгдэхүүн зэргийг импортлож байна. АНУ-ын Сиэтл хот дахь “Боинг” компанийн иргэний нисэх онгоцны үйлдвэрээс “Боинг 737-800” онгоц худалдан авахаар сонирхож байна.

1990 оноос эхлэн АНУ-ын Засгийн газар Монголд санхүү, эдийн засгийн тусламж тасралтгүй үзүүлж байна. 1990-2000 онд эрчим хүчний салбарыг дэмжих, эдийн засгийн бодлогыг дэмжих, ардчиллыг бэхжүүлэх, хүнсний тусламж гэсэн үндсэн дөрвөн чиглэлээр нийт 130 орчим сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлээд байна. Үүнээс 1999/2000 онд 12 сая ам.долларт эдийн засгийн бодлогыг дэмжих, болоод бусад төсөлд олгосон бол 2000-2001 онд 11,7 сая ам.долларын тусламж олгов. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын айлчлалын явцад 3,5-3,6 сая ам.долларын буцалтгүй тусламж болох 25 мянган тонн улаан буудайн гэрээнд гарын үсэг зурлаа. Монголын иргэний нисэхэд сэлбэг төхөөрөмжийн тусламж үзүүлэх, нисэгчдийг сургахад 150 мянган ам.долларын тусламж амлалаа. Нийт 3,7 сая орчим ам.долларын буцалтгүй тусламж авах болсон билээ. Эдгээр тусламж нь эрчим хүчний салбарыг дэмжих, цахилгаан станцуудын найдвартай ажиллагааг хангах, нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн шилжилт, бодлогыг дэмжих, ардчиллыг бэхжүүлэх гэх мэт төслүүдийг санхүүжүүлэхэд зориулагдан үр ашгаа өгч байна.

АНУ-ын Олон улсын хөгжлийн эгентлаг (ОУХА) нь Монгол Улсад эдийн засгийн туслалцаа үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хөтөлбөр нь Зах зээлд тулгаарласан тогтвортой эдийн засгийг

хөгжүүлэх болон Ардчиллыг бэхжүүлэх гэсэн гол хоёр чиглэлд анхаарлаа төвлөрүүлж байна. ОУХА-аас санхүүжүүлэн Монголд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа бүр харилцан уялдаатай дээрх хоёр чиглэлийн зорилтыг хангахаар зохион байгуулагдсан байдаг билээ.

Энэ санхүүгийн жил нь АНУ-ын ОУХА болон Монгол улс хорондын хамтын ажиллагааны эхний арван жилийн дуусгавар болж байгаагаараа онцлог юм. ОУХА нь 1991 оны 11 дүгээр сард Монгол улсын Засгийн газартай буцалтгүй тусламжийн тухай анхны гэрээг байгуулсан билээ. Уг гэрээний дагуу тэр үед эдийн засгийн хүндрэлд орсон Монгол улсад 10 сая ам.долларын өртөг бүхий яаралтай санхүүгийн тусламж үзүүлсэн бөгөөд дараагийн жилүүдэд хөтөлбөрийн хүрээнд нэмэгдэл яаралтай тусламж үзүүлэх эрчим хүчний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, эдийн засаг болон улс төрийн цаашдын шинэчлэлийн суурийг тавих зэрэгт сэтгэл харамгүй туслалцаа үзүүлж ирлээ.

1991 оноос 2001 он хүртэлх арван жилийн хугацаанд АНУ-ын ОУХА-аас Монгол улсад үзүүлсэн нийт буцалтгүй тусламжийн хэмжээ 100 гаруй сая ам доллар болов. ОУХА-ийн хөтөлбөрийг АНУ-ын Элчин сайдын яаманд байрладаг 7 хүний бүрэлдэхүүнтэй Монголдахь АНУ-ын ОУХА удирдан зохицуулдаг. Уг агентлагтай гэрээт гүйцэтгэгч байгууллагууд нь өөр хоорондоо уялдаа холбоотой ба Монголын төр, хувийн хэвшлийнхэнтэй хамтран тодорхой төслүүд хэрэгжүүлж байна.

Одоо хэрэгжүүлж буй хөтөлбөр

Монгол дахь АНУ-ын ОУХА-ийн хөтөлбөрийн одоогийн стратеги нь 1999 оноос 2003 он хүртэлх хугацааг хамарч байна. Энэхүү Стратегийн баримт бичиг нь богино хугацааны яаралтай тусламжийн хэлбэрээс урт хугацаанд тогтвортой хөгжлийг дэмжих хэлбэрт шилжихийг тусгаснаараа онцлогтой. Түүнчлэн Стратеги нь ОУХА-аас Монгол улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үндсэн хоёр зорилтыг нэгтгэж ардчиллыг дэмжин хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг бэхжүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

Өнөөгийн хэрэгжүүлж буй стратегийн нэгдүгээр зорилт "Монголын ардчилсан шилжилтийг бэхжүүлэх" явдал бөгөөд энэ нь үндсэн хоёр чиглэлээс бүрдэнэ. Үүнд:

1. Шүүх эрх мэдлийн шинэтгэл: АНУ-ын муж улсуудын шүүхийн үндэсний төвөөс хэрэгжүүлж буй энэхүү хөтөлбөр 2001 оны 3 дугаар сард эхэлж шүүн таслах ажиллагааны менежмент, шүүхийн захиргаа.

хөгжүүлэх болон Ардчиллыг бэхжүүлэх гэсэн гол хоёр чиглэлд анхаарлаа төвлөрүүлж байна. ОУХА-аас санхүүжүүлэн Монголд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа бүр харилцан уялдаатай дээрх хоёр чиглэлийн зорилтыг хангахаар зохион байгуулагдсан байдаг билээ.

Энэ санхүүгийн жил нь АНУ-ын ОУХА болон Монгол улс хорондын хамтын ажиллагааны эхний арван жилийн дуусгавар болж байгаагаараа онцлог юм. ОУХА нь 1991 оны 11 дүгээр сард Монгол улсын Засгийн газартай буцалтгүй тусламжийн тухай анхны гэрээг байгуулсан билээ. Уг гэрээний дагуу тэр үед эдийн засгийн хүндрэлд орсон Монгол улсад 10 сая ам.долларын өртөг бүхий яаралтай санхүүгийн тусламж үзүүлсэн бөгөөд дараагийн жилүүдэд хөтөлбөрийн хүрээнд нэмэгдэл яаралтай тусламж үзүүлэх эрчим хүчний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, эдийн засаг болон улс төрийн цаашдын шинэчлэлийн суурийг тавих зэрэгт сэтгэл харамгүй тусалцаа үзүүлж ирлээ.

1991 оноос 2001 он хүртэлх арван жилийн хугацаанд АНУ-ын ОУХА-аас Монгол улсад үзүүлсэн нийт буцалтгүй тусламжийн хэмжээ 100 гаруй сая ам доллар болов. ОУХА-ийн хөтөлбөрийг АНУ-ын Элчин сайдын яаманд байрладаг 7 хүний бүрэлдэхүүнтэй Монгол дахь АНУ-ын ОУХА удирдан зохицуулдаг. Уг агентлагтай гэрээт гүйцэтгэгч байгууллагууд нь өөр хоорондоо уялдаа холбоотой ба Монголын төр, хувийн хэвшлийнхэнтэй хамтран тодорхой төслүүд хэрэгжүүлж байна.

Одоо хэрэгжүүлж буй хөтөлбөр

Монгол дахь АНУ-ын ОУХА-ийн хөтөлбөрийн одоогийн стратеги нь 1999 оноос 2003 он хүртэлх хугацааг хамарч байна. Энэхүү Стратегийн баримт бичиг нь богино хугацааны яаралтай тусламжийн хэлбэрээс урт хугацаанд тогтвортой хөгжлийг дэмжих хэлбэрт шилжихийг тусгаснаараа онцлогтой. Түүнчлэн Стратеги нь ОУХА-аас Монгол улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үндсэн хоёр зорилтыг нэгтгэж ардчиллыг дэмжин хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг бэхжүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

Өнөөгийн хэрэгжүүлж буй стратегийн нэгдүгээр зорилт “Монголын ардчилсан шилжилтийг бэхжүүлэх” явдал бөгөөд энэ нь үндсэн хоёр чиглэлээс бүрдэнэ. Үүнд:

1. Шүүх эрх мэдлийн шинэтгэл: АНУ-ын муж улсуудын шүүхийн үндэсний төвөөс хэрэгжүүлж буй энэхүү хөтөлбөр 2001 оны 3 дугаар сард эхэлж шүүн таслах ажиллагааны менежмент, шүүхийн захиргаа,

эрх зүйн боловсрол ба хуульчдын ёс зүйг дээшлүүлэхэд чиглэсэн техникийн туслалцаа үзүүлэх, сургалт зохион явуулах, мөн тоног төхөөрөмжөөр хангах зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

2. Ардчиллын үйл явцыг дэмжих: АНУ-ын Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгээс хэрэгжүүлж буй энэхүү хөтөлбөр анх 1992 оноос эхлэсэн. Одоогийн үйл ажиллагаа нь улс төрийн намуудыг төлөвшүүлэх ба парламентын чадавхийг дээшлүүлэх зэрэгт чиглэгдэж байна.

Стратегийн хоёрдугаар зорилт “Эдийн засгийн өсөлтийг идэвхжүүлэх, хүрээг өргөтгөх” явдал бөгөөд энэ нь үндсэн дөрвөн чиглэлээс бүрдэнэ. Үүнд:

1. Говийн санаачилга: Говийн санаачилга нь Улаанбаатар хотоос гаднах буюу хөдөөгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих үйл ажиллагаа явуулдаг. Хөтөлбөрийг Мерси кор байгууллага ПАКТ болон Лэнд О Лэйкс-тэй хамтран хэрэгжүүлдэг. 1999 оны 1 дүгээр сард эхэлсэн уг хөтөлбөр нь бэлчээрийн менежментийг сайжруулах, малчид болон жижиг, дунд аж ахуйн нэгжид техникийн туслалцаа үзүүлэхд, радио хөтөлбөр, сар тутмын Хөдөөгийн Бизнес Мэдээ сонин болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан бизнесийн мэдээллийг өргөнөөр хүргэх, түүнчлэн ХасБанкаар дамжуулан хөдөөд зээлийн санхүүжилт хийх зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

2. Өрсөлдөх чадварын санаачилга: Нэйтэн ассосиэйтс нь Жи.И. Остин-тэй хамтран хэрэгжүүлж буй энэхүү хөтөлбөр 2000 оны 9 дүгээр сард эхэлсэн. Хөтөлбөр нь бүтээмжээ дээшлүүлэхд, оргил амжилтанд хүрэх зорилго бүхий компаниудтай шууд ажилладаг. Мах, ноолуур болон аялал жуулчлал гэсэн гол гурван салбарт хөтөлбөрийн үйл ажиллагаа төвлөрч байна. Мөн бизнесийн таатай орчин бүрдүүлэх, олон улсын зах зээл дэх Монголын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төр болон хувийн хэвшлийнхний санаачилгыг дэмжин ажилладаг.

3. Өмч хувьчлал: АНУ-ын ОУХА-ийн санхүүжилтээр 1998 оны 4 дүгээр сараас эхлэн хэрэгжиж байгаа хувьчлалын хөтөлбөрийн хүрээнд Баренц групп нь төрийн өмчийн менежмент болон хувьчлалыг хариуцсан Төрийн өмчийн хороо (ТӨХ)-той нягт хамран ажилладаг. ТӨХ-д 47 аж ахуйн газрыг битүүмжилсэн дуудлага худалдаагаар хувьчлахад туслалцаа үзүүлсэн бөгөөд эдгээр ажахуйн хувьчлалаас 15 сая гаруй ам.долларын орлогыг оруулсан. Мөн Баренц групп нь ТӨХ-

д их хувьчлалыг олон улсын тендэрээр явуулахад техникийн туслалцаа үзүүлж байна.

4.Бодлогын шинэтгэл: Девелопмент Алтернативз-ээр дамжуулан 1995 оны 6 сараас эхлэн хэрэгжүүлж буй Эдийн засгийн бодлогыг дэмжих төсөл нь эдийн засгийн шинэчлэлийн өргөн хүрээтэй асуудлуудад шуурхай хариулт өгөх механизм болж байна. Одоо хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд Ерөнхий сайдын албанд эдийн засгийн зөвлөлгөө өгөх санхүүгийн салбарын шинэчлэл төслөөр дамжуулан ХААН банкинд туслалцаа үзүүлэх, Пи Эй консалтинг-тай хамтран Эрчим хүчний салбарын шинэтгэл төслийн хүрээнд хараат бус Эрчим хүчний зохицуулах албыг байгуулах, шинэчлэн байгуулагдсан эрчим хүчний нэгжүүдийг арилжааны горимд шилжүүлэх зэрэг ажлууд орж байна.

Түүнчлэн АНУ-ын ОУХА-аас Монгол улсын эдийн засгийн өсөлт, иргэний нийгмийг дэмжих хэд хэдэн жижиг төслийг санхүүжүүлдэг. Үүнд: АНУ-ын Дотоод хэргийн департаментаар дамжуулан “Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын менежментийг сайжруулах” төсөл, Монгол, Америкийн бизнесийг холбох “Дэлхийн технологийн сүлжээ” төсөл, АНУ-д эдийн засгийн чиглэлээр Магистрын зэрэг хамгаалах хөтөлбөр, АНУ-ын Эрчим хүчний департаментаар дамжуулан хэрэгжүүлсэн “Монгол улсын салхины эрчим хүчний нөөцийн үнэлгээ” хөтөлбөр, хотын асуудлаарх “Олон улсын нөөц хотууд” хамтын ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар хотод байгуулагдсан амьдралын боломж муутай залуучуудад зориулсан Дон Боскогийн Техник мэргэжлийн төв-ийг тоноглоход дэмжлэг үзүүлэх төсөл ордог.

АНУ-аас Монгол Улсад 1999-2003 оны хооронд үзүүлэх тусламж дэмжлэгийг жил бүр 12 сая ам.доллараар төлөвлөсөн бөгөөд энэ нь Монгол Улс ардчиллын замаар тууштай замнаж, шинэчлэлтийн үйл явцыг дуусгах, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаснаар ард иргэддээ ардчилал, чөлөөт зах зээлийн үр шимийг хүртэхэд бодит дэмжлэг болж, хувьчлалыг явуулан, хувийн секторыг зогсолтгүй хөгжүүлэхэд амин чухал юм.

АНУ-ын шууд хөрөнгө оруулалт Монголд 1990 оноос эхэлсэн бөгөөд 2000 оны эцсээр оруулсан нийт хөрөнгийн хэмжээ 27,335 сая ам.доллар болов. АНУ-ын хөрөнгө оруулалттай нийт 56 компани бүртгэгдсэнээс 28 нь АНУ-ын зуун хувийн хөрөнгө оруулалттай компаниуд байна.

Тэдгээрээс үйл ажиллагаа нь жигдэрсэн томоохон хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийг товч дурьдвал:

-“Монгол Амикал” үйлдвэр нь 1990 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн. Тэмээний ноос, ямааны ноолуур боловсруулж АНУ-ын болон Европын зах зээлд экспортлодог. Дүрмийн сан нь 12048 мянган ам.доллар.

-“Мон-Форрте” компани нь 1994 оноос үйл ажиллагаагаа эхэлж тэмээний ноос, ямааны ноолуур боловсруулж АНУ-ын болон Европын зах зээлд экспортолдог. Дүрмийн сан нь 1750 мян.ам.доллар.

-“Соко” болон “Баян гол” компани нь газрын тос хайх, олборлох боловсруулах үйлдвэрлэл явуулахаар үйл ажиллагаагаа эхлээд байна.

-“Вагнер Азий Тоног-төхөөрөмж” 100 хувийн АНУ-ын хөрөнгө оруулалттай компани. Уул уурхайн тоног төхөөрөмжийг түрээслэх, худалдааны үйл ажиллагаа явуулж байна. 1,1 сая ам.долларын хөрөнгө оруулалттай.

Энэ хугацаанд Монгол Улсын уул уурхай, зам барилга, хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгжүүдэд “Катерниллер”-ын 300 орчим тоног төхөөрөмж нийлүүлж, худалдаа, түрээс, засвар үйлчилгээ явуулсаар ирлээ. Үйл ажиллагаа явуулсан таван жилийн хугацаандаа “Вагнер Ази тоног төхөөрөмж” ХХК Монгол Улсын төсөв бүрдүүлэхэд нийтдээ 2,8 сая ам.долларын татварыг улсын төсөвт оруулжээ. Мөн “Форд мотор” компанийг Монголд төлөөлж хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий “Фордын” долоон загварын 100 шахам машиныг Монголдоо зах зээлд борлуулжээ.

Дөрөв. Соёл, боловсрол, шинжлэх ухааны харилцаа

Монгол Улс, АНУ-ын хооронд соёл, боловсролын салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт 1989 оны 9 дүгээр сард гарын үсэг зурсан. Уг хэлэлцээрийн хүрээнд холбогдох байгууллагуудын тохиролцоогоор 1990 оноос манай улсад англи хэлний багш нар ирж ажиллаж байна.

Монголын нийгмийг цаашид ардчилахад АНУ-аас суралцах нь чухал юм. Энэ үүднээс АНУ-ын үндсэн хуулийг монгол хэлээр оруулан гаргасан нь үүнд ач холбогдолтой хувь нэмэр болов. Энэ мэтчилэнгээр АНУ-аас суралцахад тус болох нэлээд бүтээл орчуулагдаж, Монголын эрдэмтэд өөрсдөө туурвин бичлээ.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Азийн сан, Нээлттэй хүрээлэн-Соросын сан болон АНУ-ын мэдээллийн агентлаг зэрэг

байгууллагууд манай холбогдох яам, их дээд сургууль, бусад байгууллагаас тохиролцох замаар оюутан авч, өөрсдийн зардлаар сургаж байна. ОУХА, Мэдээллийн агентлагийн шугамаар АНУ-ын Засгийн газрын зардлаар одоогийн байдлаар 20 гаруй оюутан америкийн янз бүрийн хотуудад магистрын зэргээр сурч байна. Мөн зарим агентлагууд, шашны байгууллагууд АНУ-д оюутан илгээж сургах ажлыг зохион байгуулж байна. Тэдгээрийн шугамаар АНУ-д бүрэн бус мэдээгээр 300 гаруй оюутан сурч байгаа ажээ.

Монгол Улсын ШУА, Америкийн эрдэм шинжилгээний нийгэмлэгүүдийн зөвлөлийн хооронд 1988 оны 5 дугаар сард хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулснаас хойш хоёр талын хооронд хэд хэдэн хэлэлцээр, салбар тохиролцоо байгуулагдан эрдэмтэд солилцож байна. Эдүгээ хоёр тал байгаль орчны зэрэг салбарт эрдэмтэд солилцох, төсөл хэрэгжүүлэх хамтын ажиллагаа хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2001 оноос АНУ-тай хамтран Хөвсгөл нуурыг хамгаалах төсөл хэрэгжиж байна.

Нью-Йорк хотоос холгүй Ньв-Жерси мужид 2001 оны 6 дугаар сарын 9-нд монгол туургатан цуглаж Чингис хаанаа хүндэтгэх ёслол хийв. Энэхүү арга хэмжээг Монгол-Америкийн соёлын нийгэмлэгээс (МАКА) зохион байгуулсан бөгөөд ёслолын ажиллагаанд Элчин сайд Ж.Чойнхор болон НҮБ-ын хуралд оролцож буй Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, манай ЭСЯ, БТГ-ын дипломат ажилтнууд, монголын урлаг, спортын төлөөлөгчид, АНУ-д ажиллаж, аж төрж буй монголчууд оролцов.

Монгол-Америкийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд идэвхтэй ажиллаж ирсэн МАКА-ийн тэргүүлэгч гишүүн Тони Эттингер, Монгол орныг америкчуудад таниулан сурталчлах, уртын дууг хөгжүүлэх үйлст үнэтэй хувь нэмэр оруулж байгааг нь үнэлэн Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Ж.Энхсайхан, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын жүжигчин, төрийн соёрхолт дуучин Норовбанзад нарыг нийгэмлэгийн хүндэт өргөмжлөлөөр шагнажээ.

Хоёр орны хэвлэл мэдээллийн салбарын харилцаа өргөн хүрээтэй юм. Тухайлбал, 2001 оны 7 дугаар сард Монголын хэвлэлийн хүрээлэнгийн захирал Д.Цэдэн-иш тэргүүтэй арав гаруй сэтгүүлч, хэвлэл, мэдээллийн удирдах ажилтнууд АНУ-д айлчиллав. 2002 оны 4-р сарын эхээр “Америк-Монголын харилцааны мөчлөг” фото үзэсгэлэнг хоёр орны хооронд дипломат харилцаа тогтсоны 15 жилийн ойд зориулан Улаанбаатар хотод гаргав. Уг үзэсгэлэнд:

-1857 онд Америкийн нэрт эрдэмтэн Жозеф Лейди "Монгол нутагт анх хүн үүссэн байж болох тухай" санааг дэвшүүлсэн цагаас олон орны эрдэмтэн, ялангуяа АНУ-ын эрдэмтдийн сонирхлыг Монгол орон нэн ихээр татах болсон. Ж.Лейдиний санааг хүлээн зөвшөөрсөн профессор Г.Осборн "Ази тивийн төв хэсэгт амьтан үүссэн" гэх онолын үндэслэл гаргаж, түүнийгээ батлахаар 1918-1925 онд "Ази-Монголын говь" экспедицийг толгойлон ажиллажээ. Экспедицийн бүрэлдэхүүнд явсан доктор Гренжир Монголын Шаварын ус хэмээх газраас 100 сая жилийн өмнөх жижиг хөхтөн амьтны толгойн яс тавыг анх олж машид шуугиан дэгдээсэн юм. Үүнээс эхлэлтэй профессор Р.И.Эндрюс, Г.Ф.Осборн, Гренжир, А.В.Грабо, П.Верки, Моррис, М.Аллен, Р.В.Чани, Н.К.Нелсон, А.В.Понд, Т.Шарден, Л.Роберт, Л.М.Хилл, В.Вуман зэрэг АНУ-ын эрдэмтэд 13 боть ном, судалгааны хэдэн мянган өгүүлэл, тайлан бичиж, дэлхий нийтийн хүртээл болгожээ. Энэ үед авсан тэдний фото зэрэгт тэр үеийн монголын ахуй амьдралыг тусгажээ.

-АНУ-ын дэд ерөнхийлөгч Г.А.Уэльс зүүн Азийн зарим орнууд, ЗХУ-д айлчлах замдаа Монгол улсад хоёр хоног саатан зочилж, Улаанбаатарын ойролцоох нутгаар аялж, Монголын төр засгийн удирдагч Х.Чойлбалсантай уулзаж, монголч эрдэмтэн О.Латтимор явж байсан үеийн зургууд ихээхэн сонирхолтой, түүхэн ач холбогдол бүхий гэрч юм.

-АНУ-ын ерөнхийлөгч Ж.Бушийн урилгаар Монгол улсын анхны ерөнхийлөгч П.Очирбат Америкийн нэгдсэн улсад айлчлав. Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбат Нэгдсэн Үндэсний Байгууллагын чуулганд оролцож үг хэлсэн фото зургуудыг бас дэлгэж үзүүлсэн байлаа.

-Монгол Улсын ерөнхий сайд Н.Энхбаяр АНУ-д албан ёсны айлчлал хийх хугацаандаа Сиэтл, Сан Франциско, Денвер, Бостон, Техас, Чикаго, Нью Йорк, Вашингтон хотуудад, ажил хэрэгч ярилцлага, уулзалт, албан хэлэлцээрүүд хийж шахуу хөтөлбөртэй ажилласдаг үеийн зургууд Америк-Монголын харилцааны түүхэн нэгэн үеийн фото зургийн хэлээр харуулжээ.

Тав. Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа

Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газрын хооронд 1996 онд цэргийн солилцоо, харилцан айлчлалын хэлэлцээр байгуулагдсан. Энэ чиглэлээр өндөр хэмжээнд харилцан айлчлал тогтмолжиж, төрөл бүрийн сэдвээр сургалт, семинар зохион байгуулах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хамтарсан сургууль хийх зэргээр хамтын

ажиллагаа явагдаж байна.

1991 онд анх Батлан хамгаалахын атташе харилцан томилж цэргийн харилцаа тогтоосноос хойш хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам бүр хөгжиж ирсний дээр 1992, 1995 онуудад АНУ-ын Номхон далай дахь цэргийн ерөнхий командлагч, 1994 онд мөн командлалын хуурай замын цэргийн командлагч Монгол Улсад, 1993 онд Монгол Улсын ЗХЕШ-ын дарга, 1995, 1997 онуудад Монгол Улсын Батлан хамгаалахын сайд, 1996 онд Монгол Улсын Батлан хамгаалахын дэд сайд нар АНУ-ын Номхон далай дахь цэргийн ерөнхий командлал /Хавай/-д айлчилсан.

1995 онд АНУ-ын Ерөнхийлөгч, АНУ-ийн зэвсэг, техник нийлүүлэх, худалдах, үйлчилгээ үзүүлж болох орны тоонд Монгол Улсыг оруулж 95-38 дугаар захирамж гаргажээ.

1992 оноос хойш АНУ-ын "Олон улсын цэргийнг боловсрол" (IMET) хөтөлбөрийн хүрээнд АНУ болон бүс нутгийн орнуудад зохион байгуулагдсан янз бүрийн олон улсын семинарт хэд хэдэн төлөөлөгч, сургууль дамжаанд хэд хэдэн хүн америкийн зардлаар хамрагдаад байна.

Энэ хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын тал 1999 оны байдлаар 456,12 мянган ам.доллар, төрөл бүрийн тусламжийн хүрээнд 335,0 мянган ам.доллар зарцуулаад байгаа юм. 2001 оны санхүүгийн жилд батлан хамгаалахын салбарт 375,0 мянган ам.долларын тусламж үзүүлэхээр болсон.

Хоёр орны цэргийн харилцааны 2000 он хүртлэх хугацааны төлөвлөгөө гарган ажилласан бөгөөд өнгөрсөн 1999 онд Номхон далай дахь АНУ-ын командлалын төлөөлөгчид Монголд хоёр удаа айлчилж, хоёр талын хамтын ажиллагааны хэтийн төлөв, 2000-2007 оны харилцааны чиглэлийн асуудлаар санал солилцов.

2000 оны 7 дугаар сард АНУ-ын Батлан Хамгаалахын Төрийн нарийн бичгийн даргын орлогч У.Слоком тэргүүтэй төлөөлөгчид манай улсад ажлын айлчлал хийв. Мөн АНУ-ын Номхон Далайн цэргийн ерөнхий командлагч Адмирал Д.Блэр тэргүүтэй цэргийн төлөөлөгчид айлчлав. Уг айлчлалын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Батлан Хамгаалахын сайд, ЗХЖШ-ын дарга, Гадаад хэргийн сайд нартай уулзаж санал бодлоо солилцсон.

Хоёр улсын Засгийн газар болон БХЯ хооронд цэргийн салбарт дараах хэлэлцээрүүдэд гарын үсэг зурж, хэрэгжүүлэн ажиллаж байна.



1. "Бейкер Мондиал-П" цэргийн эмнэлгийн хамтарсан сургалт явуулах тухай Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1994.07.10/

2. "Бейкер Монгууз" Барилгын цэргийн хамтарсан сургалт явуулах тухай Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1994.07.21/

3. "Бейкер Монгууз-Ш" сургалт явуулах тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, АНУ-ын Ази, Номхон далай дахь хуурай замын цэргийн командлал хоорондын меморандум /1995.08.25/

4. "Бейкер Монгууз-П" сургалт явуулах тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, АНУ-ын Ази, Номхон далай дахь хуурай замын цэргийн командлал хоорондын меморандум /1995.08.02/

5. Цэргийн айлчлал солилцооны тухай Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1996.6 дугаар сар/

1997, 1998 онд явагдсан Монгол, Америкийн цэргийн хамтарсан "Баланс Мэжик" дадлагыг 1999 оны 2-3 дугаар сард Зүүнбаянд, "Бейкер Монгууз" сургалтын хүрээнд АНУ-ын барилгын цэргийнхэн Улаанбаатар хотын "Энэрэл" төвийн засварын ажлыг 7, 8 дугаар сард хэрэгжүүлсэн болно.

Америкийн тав Монголын Засгийн газрын хүсэлтийг хүлээн авч, НАТО-гийн "Энхийн төлөө түншлэл"-ийн хүрээнд явагддаг Төв Азийн орнуудын "Centrasbat" команд штабын хээрийн сургуульд монголын цэргийн ажиглагчдыг өөрийн зардлаар оролцуулав. Түүнчлэн 2000 оны 9 дүгээр сард Казахстан Улсад болсон "Centrasbat-2000" хээрийн сургуульд Монгол Улсын Зэвсэгт хүчний нэг салаа амжилттай оролцсон.

Хилийн цэргийн холбоожилтын төслийг хэрэгжүүлэхээр эхний ээлжинд 1,9 сая ам.долларыг 2001 оны санхүүгийн жилд ологохоор АНУ-ын Засгийн газар шийдвэрлэсдэн. Одоо хоёр тал төслийн хүрээнд авах тоног төхөөрөмжийн талаар тохиролцож байна.

Хоёр талын батлан хамгаалах салбарын харилцааны зорилго нь Монголын зэвсэгт хүчнийг ардчиллын нөхцөлд тэдний үүрэг зорилгод зохицуулах болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд америкийн тал дэмжлэг үзүүлэх, мөн тэднээс гадаад орны мэргэжил нэгтнүүдтэй тогтоосон харилцааг нэмэгдүүлэх, хэтдээ олон улсын энхийг сахиулах хүчинд оролцох чадвартай болгоход оршино.

Зургаа. Иргэдийн харилцаа

Монгол, Америкийн харилцаанд цаашдын хөгжилд ардын дипломатын харилцаа чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм. Тухайлбал, Монгол улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын урилгаар АНУ-ын Ерөнхийлөгч асан Жимми Картер манай улсад 2001 оны 9 дүгээр сарын 8-10-нд айлчилла. Уг айлчлал, Монгол-Америкийн харилцааг өргөтгөхөд чухал ач холбогдолтой болсон юм. Мөн АНУ-ын Ерөнхийлөгч асан Буш, Монгол орон ардчиллын замаар тууштай замнаж явааг сайшааж, өөрийн зүгээс боломжит бүх дэмжлэг үзүүлэх эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлээд, 2002 оны 5 дугаар сард Монголд айлчлан очих бодолтой байгаагаа мэдэгдсэн юм. Тэрбумтан санхүүжүүлэгч Ж.Сорос Монголд айлчилан “Даяарчил, түүний Монгол дахь үр нөлөө” сэдэвт уулзалтанд оролцов. Монголд байгуулсан нээлттэй нийгэмлэгийн ажил сайн явж байгааг нүдээр үзжээ.

Тэрчилэн Монголын иргэд АНУ-д олон мянгаар зорчих, амьдрах болсон нь тус улсын хөгжил дэвшил, ардчиллаас суралцахад сайхан боломж олгож байгаа юм. 2001 оны 7 дугаар сард Монгол Улс, АНУ-ын иргэд харилцан зорчиход визийн хөнгөлөлт үзүүлэх шинэ журмын тухай ноот бичигт гарын үсэг зурав.

Монгол Улсын Гадаад хэргийн дэд сайд С.Батболд, АНУ-ын Элчин сайд Жон Р.Дингер нар хоёр улсын иргэдэд харилцан олгох визийн журмын талаар 7 дугаар сарын 6-нд Гадаад хэргийн яаманд ноот бичиг солилцов. Энэ ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр оролцов. Визийн шинэ журмын дагуу Монголын иргэд АНУ-д жуулчлах, бизнесийн зорилгоор зорчих бол 10 жил, суралцахад 5 жил, албан ажлаар зорчих бол 3 жилийн хугацаанд олон удаа зорчих виз олгоно. АНУ-ын иргэд Монголд хувийн хэргээр түр хугацаагаар зорчих, жуулчлахад визгүй зорчино. Харин суралцах бол 5 жил, бусад тохиолдолд 3 жилийн хугацаанд олон удаа зорчих виз олгоно. Хоёр улс визийг хураамжгүй олгоно. Энэ журам 2001 оны 7 дугаар сарын 18-наас мөрдө

€ гдөж эхэлсэн.⁴

а: Энэ журам мөрдөхөөс өмнө нь АНУ-ын визийг 10 мянга орчим
сг монгол хүмүүс авсан байна. 2001 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр
нг АНУ-д суугаа элчин сайд Ж.Чойнхорын мэдээлснээр тэр үед АНУ-д
7000 монголын иргэн оршин сууж байгааг тэмдэглэсэн юм. Гэхдээ АНУ-
салт нэвтрэх виз авах нь амаргүй хэвээр байгаа боловч 2001 оны 9 дүгээр
байр ын 11-ний аймшигт үйл явдлаас хойш 300 гаруй монгол хүн АНУ-

д зорчих виз авсан байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын АНУ-ын ерөнхийлөгч Ж.Буштай уулзах үеэр АНУ-д оршин суух манай иргэдэд ялангуяа залуучуудад тодорхой хугацаанд хуулийн дагуу хөдөлмөр эрхлэх эрх олгох талаар тусалбал оюутнууд олноор суралцах боломж нээгдэх, энэ нь цөөн тооны хүний гухай асуудал болохыг ярилцсан билээ. Тэгэхэд Ж.Буш "Манай цагаачлалын албаны дүрэм журам нэлээд чанга. Гэхдээ туслах бололцоог судалж үзье... эдгээр асуудлыг зохицуулахад болохооргүй хэцүү зүйл биш байна" гээд анхаарч судлахыг холбогдох хүмүүстээ үүрэг болгожээ.

Монгол улс АНУ-тай стратегийн түшнлэлийн харилцаа хөгжүүлэх явцдаа АНУ-ын энэ хүнд үед нь чадах ядахаараа туслах зарчим барьж ажиллах шаардлагатай юм. Бид зовж байхад бусад улс туслах ёстойгоос бус, бусад улс зовж байхад бид туслах албагүй гэдэг үүднээс хандвал стратегийн түшнлэл хэзээ ч үүсэхгүй" гэж Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр онцлон тэмдэглэжээ. Энд Монгол Улс агаарын орон зайгаа ашиглуулах болон бусад асуудал орж байгаа юм. Монгол Улсын Засгийн газар АНУ-д болсон үйл явдалтай холбогдуулан хүмүүнлэгийн тусламж болгон 250 мянган флакон панкипсинг нийлүүлж байв.

Монгол Улс агуу их Америк гүрэнтэй дотно харилцаатай болж, хоёр орон цаашид хамтран ажиллах дардан зам нээгдэн, стратегийн түншүүд болж, хоёр орон алс хол ч сайн нөхөд болсон билээ.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. Зууны мэдээ. 2001.1.16.
2. Зууны мэдээ. 2001.11.13. №268 (342)
3. Зууны мэдээ. 2001.10.01.
4. Гадаад харилцаа. №8.(103)